



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2018 оны 11 дүгээр сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 11 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24%-иар буюу 2,261 сая ам.доллараар өсч 11,852 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 14%-иар буюу 794 сая ам.доллараар, импорт 38%-иар буюу 1,467 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 673 сая ам.доллараар буурч 1,109 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 11 сар			Өөрчлөлт			
	2015	2016	2017	2016/2015		2017/2016		2016	2017	2018	2017/2016		2018/2017	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,467	8,274	10,536	(192)	-2%	2,262	27%	7,356	9,591	11,852	2,235	30%	2,261	24%
Экспорт	4,669	4,916	6,201	247	5%	1,284	26%	4,276	5,686	6,481	1,410	33%	794	14%
Импорт	3,798	3,358	4,335	(439)	-12%	977	29%	3,080	3,905	5,372	825	27%	1,467	38%
Тэнцэл	872	1,558	1,865	686		307	20%	1,197	1,782	1,109	585	49%	(673)	-38%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2018 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 505 сая ам.доллараар буурч 1,441 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 66% буюу 7,827 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 14% буюу 1,614 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 38%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 28%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5%-иар өссөн бол өмнөх сараас 11%-иар буурч 1.731-д хүрлээ. Худалдааны нөхцөл өмнөх сараас муудахад чулуун нүүрсний үнийн бууралт голлон нөлөөлөв.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2018 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 14%-иар буюу 794 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 12 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.4 хувиар буурсан бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.7 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²	
1. Уул уурхай		3,666	86%		5,047	89%		5,729	88%		1,381	38%	32%	682	14%	12.0%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,440	1,497	35%	1,315	1,441	25%	1,311	1,824	28%	(56)	-4%	-1%	383	27%	7%	
1.2. Чулуун нүүрс	22,019	772	18%	30,981	2,111	37%	33,355	2,617	40%	1,339	173%	31%	506	24%	9%	
1.3. Боловсруулаагүй нефть	7,344	302	7%	6,940	341	6%	5,669	367	6%	39	13%	1%	25	7%	0%	
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	5,903	234	5%	5,589	281	5%	6,743	308	5%	47	20%	1%	26	9%	0%	
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	14,254	577	13%	13,211	541	10%	3,432	144	2%	(36)	-6%	-1%	(396)	-73%	-7%	
1.6. Цайрын хүдэр, баяжмал	117	132	3%	109	165	3%	114	184	3%	32	24%	1%	19	12%	0%	
1.7. Жонош, лейцит, нефелинт	227	54	1%	281	73	1%	492	166	3%	19	34%	0%	93	127%	2%	
1.8. Молибдений хүдэр, баяжмал	5	23	1%	6	34	1%	5	45	1%	11	47%	0%	11	32%	0%	
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	10	0%	1	8	0%	1	7	0%	(2)	-22%	0%	(0)	0%	0%	
1.10. Мөнгө /тонн/	89	37	1%	0	1	0%	0	1	0%	(36)	-98%	-1%	(0)	0%	0%	
1.11. Бусад	98	27	1%	376	51	1%	484	67	1%	24	20x	1%	16	31%	0%	
2. Мал аж, ахуй	174	293	7%	316	357	6%	366	450	7%	64	22%	2%	93	26%	1.6%	
2.1. Амьд мал, малын мах	7	16	0%	23	44	1%	34	73	1%	28	182%	1%	29	65%	1%	
2.2. Арьс, шир	144	20	0%	266	20	0%	305	15	0%	(1)	-3%	0%	(5)	-25%	0%	
2.3. Малын өлөн гэдэс	0	6	0%	0	6	0%	1	7	0%	0	7%	0%	1	0%	0%	
2.4. Ноолуур	7	229	5%	7	259	5%	9	326	5%	29	13%	1%	67	26%	1%	
2.5. Ноос, бусад үс, хялгас	15	21	0%	17	27	0%	14	26	0%	6	28%	0%	(0)	-2%	0%	
2.6. Бусад	0	2	0%	1	2	0%	4	3	0%	1	38%	0%	1	36%	0%	
3. Газар тариалан	123	19	0%	152	13	0%	45	12	0%	(5)	-29%	0%	(1)	-11%	0.0%	
4. Аж үйлдвэрлэл	240	298	7%	355	268	5%	203	289	4%	(30)	-10%	-1%	21	8%	0.4%	
4.1. Хүнс	7	34	1%	18	72	1%	29	78	1%	38	113%	1%	6	8%	0%	
4.2. Ноолууран эдлэл	1	24	1%	1	30	1%	1	33	1%	6	27%	0%	3	1%	0%	
4.3. Бусад хувцас, пүтэл, эдлэл	2	13	0%	3	15	0%	3	23	0%	2	13%	0%	9	60%	0%	
4.4. Уул уурхай	28	79	2%	33	102	2%	50	98	2%	23	29%	1%	(4)	-4%	0%	
4.5. Цахилгаан, электрон бараа	0	5	0%	0	1	0%	0	3	0%	(4)	-81%	0%	2	267%	0%	
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	136	3%	2	42	1%	3	49	1%	(94)	-69%	-2%	6	15%	0%	
4.7. Бусад	203	8	0%	300	6	0%	118	4	0%	(2)	-22%	0%	(2)	-26%	0%	
5. Бусад	1	1	0%	1	1	0%	1	1	0%	0	2%	0%	0	13%	0.0%	
Нийт дүн		4,276		5,686			6,481			1,410	33%		794	14%		

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2018 оны 11 дүгээр сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	(173)		855		682	14%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(6)	-1%	388	101%	383	27%
1.2. Чулуун нүүрс	186	37%	320	63%	506	24%
1.3. Боловсруулаагүй нефть	(82)	-325%	108	425%	25	7%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	53		(26)		26	9%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(412)	104%	16	-4%	(396)	-73%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	9	45%	10	55%	19	12%
1.7. Жонош, лейцит, нефелинт	71	77%	21	23%	93	127%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(4)	-40%	15	140%	11	32%
1.11. Бусад	15	95%	1	5%	16	31%
2. Мал аж, ахуй	74		19		93	26%
2.1. Амьд мал, малын мах	22	77%	7	23%	29	65%
2.2. Арьс, шир	2	-38%	(7)	138%	(5)	-25%
2.3. Малын өлөн гэдэс	1	93%	0	7%	1	0%
2.4. Ноолуур	53	79%	14	21%	67	26%
3. Газар тариалан	(28)		26		(1)	-11%
4. Аж үйлдвэрлэл	81		(60)		21	8%
5. Бусад	(1)		1		0	13%
Нийт дүн	(47)		841		794	14%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

2018 оны эхний 11 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 47 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 841 сая ам.доллараар өссөн байна. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 181 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 708 сая ам.доллараар өссөн байна. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 81 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 60 сая ам.доллараар буурсан байна.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2018 оны 11 дүгээр сард 1,221 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5%-иар буурсан хэдий ч өнгөрсөн сараас 0.5%-иар өссөн байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,196; 73 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 9%-иар буурсан, харин төмрийн хүдэр 14%-иар өссөн бол өнгөрсөн сараас зэс 0.4%-иар, төмрийн хүдэр 0.2%-иар буурсан байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 11 дүгээр сард 74 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 5%-иар өссөн хэдий ч өмнөх сараас 8%-иар буурсан байна.

Импорт 2018 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 38%-иар буюу 1,467 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 18 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 7 нэгж хувийг, аж үйлдвэрийн орц бүтээгдэхүүний өсөлт 4 нэгж хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²	
Хэрэглээний бүтээгдэхүүн		1,064	35%		1,166	30%		1,491	28%		102	10%	3%	324	28%	8%
Түргэн эдэлгээтэй	762	590	19%	767	661	17%	888	784	15%	71	12%	2%	122	18%	3%	
Хүнс	359	409	13%	353	459	12%	423	542	10%	50	12%	2%	83	18%	2%	
Эм, тариа	2	83	3%	2	86	2%	3	107	2%	3	4%	0%	21	25%	1%	
Бусад түргэн эдэлгээтэй бараа	401	99	3%	412	117	3%	463	135	3%	18	18%	1%	18	15%	0%	
Удаан эдэлгээтэй	120	474	15%	190	505	13%	214	707	13%	31	7%	1%	202	40%	5%	
Гутал, хувцас, цүнх	42	49	2%	61	57	1%	57	69	1%	8	17%	0%	12	21%	0%	
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	23	88	3%	69	83	2%	84	107	2%	(5)	-6%	0%	24	29%	1%	
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	280	9%	1	305	8%	2	455	8%	25	9%	1%	150	49%	4%	
Бусад удаан эдэлгээтэй бараа	54	57	2%	59	60	2%	71	77	1%	3	6%	0%	16	27%	0%	
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,022	1,077	35%	1,020	1,510	39%	1,356	2,205	41%	434	40%	14%	695	46%	18%	
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	15	634	21%	24	948	24%	29	1385	26%	313	49%	10%	437	46%	11%	
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	205	7%	1	298	8%	1	406	8%	93	45%	3%	108	36%	3%	
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	14	429	14%	23	649	17%	28	978	18%	220	51%	7%	329	51%	8%	
Барилгын материал	667	268	9%	571	406	10%	739	615	11%	137	51%	4%	209	51%	5%	
Хөрөнгө оруулалтын бусад бараа	50	174	6%	55	156	4%	42	206	4%	(17)	-10%	-1%	49	31%	1%	
Аж үйлдвэрлэлийн орц	939	466	15%	1,266	500	13%	1,431	664	12%	33	7%	1%	164	33%	4%	
Хүнсний орц	187	52	2%	38	18	0%	278	77	1%	(34)	-65%	-1%	59	324%	2%	
Химийн бүтээгдэхүүн	114	78	3%	168	97	2%	190	112	2%	20	26%	1%	15	15%	0%	
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	25	17	1%	42	21	1%	75	28	1%	4	21%	0%	8	37%	0%	
Цахилгаан эрчим хүч	1	111	4%	2	123	3%	1	130	2%	12	11%	0%	7	6%	0%	
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	1	0%	2	1	0%	1	1	0%	(0)	-30%	0%	(0)	-36%	0%	
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	692	208	7%	769	240	6%	811	315	6%	32	15%	1%	76	32%	2%	
Нефтийн бүтээгдэхүүн	939	467	15%	1,266	722	18%	1,431	1,006	19%	255	55%	8%	284	39%	7%	
Дизель түлш	486	222	7%	736	386	10%	764	515	10%	164	74%	5%	129	33%	3%	
АИ-92, АИ-95	296	147	5%	331	196	5%	333	238	4%	50	34%	2%	42	21%	1%	
А-80 болон бусад	157	99	3%	199	140	4%	335	254	5%	41	42%	1%	114	81%	3%	
Бусад	11	5	0%	15	7	0%	274	6	0%	1	25%	0%	(1)	-8%	0%	
Нийт дүн		3,080		3,905			5,372			825	27%		1,467	38%		

²% - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2018 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	193	59%	132	41%	324	28%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	392	56%	303	44%	695	46%
Аж үйлдвэрлэлийн орц	79	48%	85	52%	164	33%
Нефтийн бүтээгдэхүүн	123	43%	161	57%	284	39%
Дизель түлш	19	15%	110	85%	129	33%
АИ-92, АИ-95	1	2%	41	98%	42	21%
А-80 болон бусад	103	90%	11	10%	114	81%
Бусад	6		(6)		(1)	-8%
Нийт дүн	792	54%	675	46%	1,467	38%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2018 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 695 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 324 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 284 сая ам.доллараар, аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 164 сая ам.доллараар тус тус өссөнөөр нийт импорт 1,467 сая ам.доллараар өссөн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2018 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 28 хувиар, өмнөх сараас 4 хувиар өсч тонн тутамд 792 ам.долларт хүрэв.